



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/68/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033

Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805

Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955

Цахим хаяг: Gantuya.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	Error! Bookmark not defined.
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Error! Bookmark not defined.
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	5
3.1. Ерөнхий зүйл.....	5
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	5
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	5
3.4. Материаллаг байдал	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	7
3.7. Шилэн дансны мэдээлэл	7
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт	8
Залруулсан алдаа	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	8
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	9
4. Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	11

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

№ 25
танай _____ -ны № _____ -т

БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Э.ГЭРЭЛМАА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Э.Гэрэлмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалыг нэр төрлөөр нь, үнэн зөв гаргаж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж, шаардах хуудсаар зарлагдахгүй, үлдэгдэлээр тайлагнаж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баян-өндөр сумын ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Сум орон нутгийн эдийн засаг нийгмийн үйл ажиллагааны чигийг тогтоож, удирдан зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-өндөр сумын ИТХ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-өндөр сумын ИТХ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 118,565.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,185.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн

санхүүгийн тайлангийн нийт орлого 229,498.3 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул 1 хувиар буюу 2,294.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,629.1 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	228.7		-228.7
Урьдчилгаа			
Бараа материал	3,769.9	3,832.2	62.3
Үндсэн хөрөнгө	82,475.6	77,012.8	-5,462.8
Нийт хөрөнгө	86,474.2	80,845.1	-5,629.1
Өр төлбөр	228.7		-228.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	86,245.5	80,845.1	-5,400.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	86,474.2	80,845.1	-5,629.1

Мөнгөн хөрөнгө, авлага болон урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна. Авлага данс оны эхэнд 228.7 мянган төгрөгийн ХАОАТ-ын авлага байсныг барагдуулж үлдэгдэлгүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,832.2 мянган төгрөг болж 62.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь бичиг хэргийн материал оны эхэнд үлдэгдэлгүй байсан, төсвийн хөрөнгөөр 3,027.0 мянган төгрөгийн материал худалдан авч, 2,624.0 мянган төгрөгийн материал зарцуулж 403.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, тусгай зориулалтын материал данс 3,734.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэл дээр төсвийн хөрөнгөөр 1,351.1 мянган төгрөгийн материал худалдан авч 1,704.8 мянган төгрөгийн материал зарцуулж 3,381.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тус тус тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 77,012.8 мянган төгрөг болж тайлант оны 5,462.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна. Үндсэн хөрөнгөд төсвийн хөрөнгөөр СТС ХХК-аас 1,250.0 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж худалдан авч программ хангамж дансанд орлого авч бүртгэсэн. Аймгийн Засаг даргын 2020.01.21-ний өдрийн А/253 дугаар захирамжаар ашиглалтын хугацаа дууссан 40,299.3 мянган төгрөгийн үнэтэй 31 ширхэг ай пад /MD-785LL/ -ыг акталж данс бүртгэлээс хассан байна.

2020 оны санхүүгийн тайланд биет бус хөрөнгө, өр төлбөр дансанд урт болон богино хугацаат өр төлбөр бүртгэгдээгүй байна. Өр төлбөр дансанд оны эхэнд 228.7 мянган төгрөгийн НДШ-ийн өр байсныг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 80,845.1 мянган төгрөг болж тайлант оны үр дүн 5,400.4 мянган төгрөгөөр буурсан байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 222,997.2 мянган төгрөгөөр буюу 50.7 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх онд үнэ төлбөргүй орлогод

48,645.0 мянган төгрөг, аймгаас 175,576.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч байсан байна.

Нийт зардал өмнөх оноос 23,925.5 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс эд хогшил урсгал засварын зардал 471.5 мянган төгрөг, томилолтын зардал 113.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 8,668.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 14,671.3 мянган төгрөгөөр тус бүр зардлууд буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжих 270,335.4 мянган төгрөг, нийт зарлагыг 270,335.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43,837.1 мянган төгрөгөөр бууруулж нийт зардлыг 226,498.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 226,498.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 226,498.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 226,498.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 216,387.1 мянган төгрөгийг зарцуулж, 10,111.2 мянган төгрөгийн зардлын хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын хэмнэлт 10,111.2 мянган төгрөг буюу 4.4 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 4,418.6 мянган төгрөг, НДШ-ийн зардлыг 2,384.5 мянган төгрөг, томилолтын зардал 1,266.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1,030.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,011.9 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-аас ГХУСЗ-ийн зардлын 3,000.0 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснийг, сургалтад 300.0 мянган төгрөг, шатахуунд 500.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгаанд 1,000.0 мянган төгрөг, ном хэвлүүлэхэд 500.0 мянган төгрөг, шагнал урамшуулалд 700.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш 164,782.1 мянган төгрөгийн 13 орлогын гүйлгээ, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3		3				
Нийт дүн	3		3				

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 175,198.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 8,281.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 166,462.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 155.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгөд 1,250.0 мянган төгрөгийн программ хангамжийг орлогод бүртгээгүй, бараа материалын тайланд 6,574.0 мянган төгрөгийн шатах тослох материалыг дутуу бүртгэсэн, авлага, өр төлбөр тус бүр 228.7 мянган төгрөгөөр буурсан байхад үлдэгдлээр тайлагнасан нийт 8,281.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 166,762.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 166,462.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Цагийн өргөө НҮТББ-тай "эрүүл мэнд эрхэм баян" сэдэвт онлайн сургалт зохион байгуулахаар 2020.05.05-ны өдрийн 01 дугаар бүхий гэрээ байгуулж, тус байгууллагын хаан банкн дахь 5217055958 тоот дансанд тоног төхөөрөмжийн холболтын зардал 300.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлсэн боловч зарцуулалтын тайланд 2019.04.06-ны өдөр, 2019.09.21-ний өдөр технологийн сургуулийн лекцийн танхимд сургалт зохион байгуулсан баримт хавсаргаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Шилэн дансанд байршуулах 149 мэдээллээс 3 мэдээлэл хоцроож, 5.0 сая төгрөгөөс дээш 164,782.1 мянган төгрөгийн, 13 орлогын мэдээлэл, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгаан тайлбарын бүтэн жил, хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын бүтэн жилийн 2 мэдээлэлийг огт байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Оны эцэст 2020.12.22-ны өдрийн 00231 дугаар төлбөрийн хүсэлтээр 1,680.0 мянган төгрөг, 00230 дугаар төлбөрийн хүсэлтээр 1,620.0 мянган төгрөг, 00229 дугаар төлбөрийн хүсэлтээр 1,960.0 мянган төгрөг нийт 5,260.0 мянган төгрөгийн хурлын хуралдааны хоол болон ариутгалын зардал гаргаснаас 1,680.0 мянган төгрөгөөр сургалтын материал болон ном худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 155.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Бараа материалын тайланг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргаагүй тусгай зориулалтын материалын эхний үлдэгдэл дээр бүх бараа материалын орлого зарлагыг бүртгэж, баримтаарх үлдэгдэл 3,797.2 мянган төгрөг, санхүүгийн тайлангийн үлдэгдэл 3,832.2 мянган төгрөг буюу 35.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." заалтуудыг хэрэгжүүлэн бараа материалыг нэр төрлөөр нь, үнэн зөв гаргаж тайлагнах.

Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тайлант онд бичиг хэргийн зардлаас 120.0 мянган төгрөгийн хард диск худалдан авч, шаардах хуудсаар зарлагдсан байна.

2.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж:

Зардлыг зориулалтын дагуу зарцуулж, шаардах хуудсаар зарлагдахгүй, үлдэгдэлээр тайлагнаж байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Баян-өндөр сумын ИТХ-д өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.02.25-ны 79 тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭЛТГЭСЭН:
АУДИТОР
(ОРА-2021/68/СТА-ТШЗ)

АУДИТЫН ТАЙЛАНГ
Ц.НАРМАНДАХ
Б.ЭРДЭНЭ
О.ГАНТУЯА

Огноо:

Огноо:

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/68/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баян-өндөр суын Иргэдийн төлөөлөгчдийн хурал		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргаагүй тусгай зориулалтын материалын эхний үлдэгдэл дээр бүх бараа материалын орлого зарлагыг бүртгэж, баримтаарх үлдэгдэл 3,797.2 мянган төгрөг, санхүүгийн программаар гаргасан тайлангийн үлдэгдэл 3,832.2 мянган төгрөг буюу 35.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	35.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Э.Гэрэлмаа П.Болорчимэг
2	Тайлант онд бичиг хэргийн зардлаас 120.0 мянган төгрөгийн хард диск худалдан авч шаардах хуудсаар зарлагдсан байна.	120.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Э.Гэрэлмаа П.Болорчимэг
3	Цагийн өргөө НҮТББ-тай "эрүүл мэнд эрхэм баян" сэдэвт онлайн сургалт зохион байгуулахаар 2020.05.05-ны өдрийн 01 дугаар бүхий гэрээ байгуулж, тус байгууллагын хаан банкн дахь 5217055958 тоот дансанд тоног төхөөрөмжийн холболтын зардал 300.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч зарцуулалтын тайланд 2019.04.06-ны өдөр, 2019.09.21-ны өдөр технологийн сургуулийн лекцийн танхимд сургалт зохион байгуулсан баримт хавсаргаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	300.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Э.Гэрэлмаа П.Болорчимэг
4	Шилэн дансанд байршуулах 149 мэдээллээс 3 мэдээлэл хоцроож, 5.0 сая төгрөгөөс дээш 164,782.1 мянган төгрөгийн 13 орлогын мэдээлэл, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгаан тайлбарын бүтэн жил, хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын бүтэн жилийн 2 мэдээлэлийг огт байршуулаагүй байна.	164,782.1	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Э.Гэрэлмаа П.Болорчимэг

Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Оны эцэст 2020.12.22-ны өдрийн 00231 дугаар төлбөрийн хүсэлтээр 1,680.0 мянган төгрөг, 00230 дугаар төлбөрийн хүсэлтээр 1,620.0 мянган төгрөг, 00229 дүгээр төлбөрийн хүсэлтээр 1,960.0 мянган төгрөг нийт 5,260.0 мянган төгрөгийн хуралдааны зардал гаргаснаас 1,680.0 мянган төгрөгөөр сургалтын материал болон ном худалдан авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	1,680.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Э.Гэрэлмаа П.Болорчимэг
ДҮН		166,917.1			

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТЫГ

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

О.ГАНТУЯА

Огноо:

Огноо:



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 98/22 ОАМ-2021/68/СТА-ТШЭ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд байршуулах 149 мэдээллээс 3 мэдээлэл хоцроож, 5.0 сая төгрөгөөс дээш 164,782.1 мянган төгрөгийн, 13 орлогын мэдээлэл, төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгаан тайлбарын 4 улирал, хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын бүтэн жилийн 2 мэдээлэлийг огт байршуулаагүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбарыг улирал бүр, 6.3.5-т "хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт", 6.4-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу сайтад мэдээллийг хоцроож, дутуу мэдээлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-өндөр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Гэрэлмаа, нягтлан бодогч П.Болорчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ 
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР  6117143650
6117143650 Б.ЭРДЭНЭ

АУДИТОР  О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 91/91 ОРН-2021/02/СТА ТЭГ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баян-өндөр сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Оны эцэст 2020.12.22-ны өдрийн 00231 дугаар төлбөрийн хүсэлтээр 1680.0 мянган төгрөг, 00230 дугаар төлбөрийн хүсэлтээр 1620.0 мянган төгрөг, 00229 дүгээр төлбөрийн хүсэлтээр 1960.0 мянган төгрөг нийт 5260.0 мянган төгрөгийн хуралдааны зардал гаргаснаас 1680.0 мянган төгрөгөөр сургалтын материал болон ном худалдан авч төлөөлөгч нарт өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-өндөр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Гэрэлмаа, нягтлан бодогч П.Болорчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 49/49 ОРА 2021/02/26-т

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Баян-өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагийн өргөө НҮТББ-тай "эрүүл мэнд эрхэм баян" сэдэвт онлайн сургалт зохион байгуулахаар 2020.05.05-ны өдрийн 01 дугаар бүхий гэрээ байгуулж, тус байгууллагын хаан банкн дахь 5217055958 тоот дансанд тоног төхөөрөмжийн холболтын зардал 300.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлсэн боловч зарцуулалтын тайланд 2019.04.06-ны өдөр, 2019.09.21-ний өдөр технологийн сургуулийн лекцийн танхимд сургалт зохион байгуулсан баримт хавсаргаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-т "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21-р зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баян-өндөр сумын ИТХ-ын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 300.0 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Баян-өндөр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Гэрэлмаа, нягтлан бодогч П.Болорчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: О.ГАНТУЯА

¹ Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955